



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/135

Чингис хот

Малын тэжээлийн үнийг хямдруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, 58.2.8, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь хэсэг, аймгийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан хавсралтанд заасны дагуу орон нутгийн нөөцөд 2018 онд бэлтгэсэн рапсыг малчдад үнэгүй, ашигт долооцын үнийг 50 хувиар хямдруулсугай.

2. Хямдарсан болон үнэгүй олгох тэжээлийг өвөлжилт хүндэрсэн сумын Засаг дарга нартай зөвшилцөн хувиарлан олгохыг Онцгой байдлын газрын дарга /Н.Чанцал/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА